

2013.02.27

## ОРЧУУЛГАЗҮЙ: Онол, арга, зарчим

### (Их семинар)

**Ш.Эгшиг:** За өнөөдрийн амар амгаланг эрье. Манай сургуульд саяхан орчуулгазүйн профессорын хамтлаг байгуулагдсан, тэгээд энэ хамтлагийн маань ажлын төлөвлөгөө ёсоор 2013 оноос бид нилээд ажлууд төлөвлөж байгаа. Үүний хамгийн эхэнд орчуулгазүйн их семинар хийе гэсэн ажил байгаа. Өнөөдөр уг нь Г.Аким гуайг бид урьсан, өчигдөрхөн утасдаад ирнэ гэж хэлсэн, сая утас нь холбогддоггүй, бид нилээн хүлээгээд хөтөлбөрийг жаахан өөрчилье гэж тогтлоо. Өнөөдөр бидний урилгыг хүлээн авч манай Гадаад хэл соёлын сургуулийн орчуулгазүйн их семинарт оролцохоор хүрэлцэн ирсэн эрдэмтэн, мэргэд, орчуулагч, дуун хөрвүүлэгч, профессорууд та бүхэнд гялайлаа. Манай өнөөдрийн их семинарт МУИС-ийн ОУХС-ийн багш, орчуулагч Т.Төмөрхүлэг, герман хэлний орчуулагч Д.Хандмаа, МУИС-ийн ГХСС-ийн Герман хэлний тэнхмийн багш, манай орчуулгазүйн хамтлагийн профессор Г.Лувсан, мөн герман хэлний орчуулагч А.Цэрэнчулуун гуай, МУИС-ийн МХСС-ийн багш, профессор Н.Балжинням, профессор доктор Л.Манлажав, ГХСС-ийн Хятад хэлний тэнхмийн багш доктор Г.Элдэв-Очир, ГХСС-ийн ахмад багш профессор Н.Доржготов, ГХСС-ийн Хятад хэлний тэнхмийн ахмад багш профессор, МУ-ын СГЗ Ц.Базаррагчаа, МХСС-ийн гадаад хэлний тэнхмийн эрхлэгч, профессор Л.Чулуунбаатар багш, Олон Улсын Харилцааны Дээд Сургуулийн Дипломат орчуулгын тэнхмийн эрхлэгч профессор Б.Энхбаяр, Улаанбаатар их сургуулийн багш Ө.Саранцэцэг, МУБИС-ийн герман хэлний тэнхмийн эрхлэгч С.Алимаа, МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн профессор С.Базарпүрэв, мөн тэнхмийн профессор Ц.Батболд болон бусад хүмүүс ирсэн байна. Өнөөдрийн их семинарыг бид нар семинар шиг хийе гэсэн бодолтой та бүхнийг урьсан. “Орчуулгазүй” гэсэн энэ сэдвийн дор та бүхэн дуртай зүйлээ ярьж, энэ семинарт суусан оюутнуудад орчуулгын талаар, онол арга зарчмын талаар мэтгэлцээн, эрдмийн их яриа өрнөх байх гэж бодож байна. Г.Аким багшийн илтгэл бол уг нь “Орчуулгын онол, арга, зарчим” гэсэн нэртэй илтгэл байх байсан, энэ удаа манай Чимидцэеэ багшийн “Монгол орчуулгын 3 үндсэн зарчим, орчуулгын тулгын 3 чулуу” гэсэн илтгэлийг гол илтгэл болгон хэлэлцүүлнэ. Та бүхэн тавтай сууж семинартаа оролцоно уу.

**М.Чимидцэеэ:** За та бүхний амар амгаланг айлтгая. Уг нь Аким гуай энд гол илтгэлийг бэлдээд, түүнийг тойруулан бид орчуулгын онол, арга зарчмын асуудлаар мэтгэлцээн



өрнүүлэе гэж анх шийдсэн юм. Аким гуайд ажил гарсан бололтой, алга байна. Тэгэхээр Аким гуайтай бидний ярьсан, урьдчилан санал тохиролцсон зүйл бол орчуулгын үндсэн зарчмын асуудлаар энэ удаагийн мэтгэлцээн, их семинарыг зохион байгуулъя гэсэн юм. Би бол хятад хэлнээс орчуулдаг хүн, хятад хэлний орчуулагч юм. Миний ярих зүйл бол монгол орчуулгаас гадна, хятад орчуулгын онол, хятад орчуулгын зүйлтэй ямар нэгэн хэмжээгээр хамааралтай ийм зүйлийг өөрийн мэргэжлийн үүднээс ярилцъя, та бүхэн орчуулгын онол зарчмыг тойруулан, энэ сэдэв бол маш өргөн хүрээтэй сэдэв учир та бүхэн үнэтэй сайхан бодол, зөвлөгөөг хэлж санал солилцоно гэж найдаж байна. Би нэгэн бяцхан илтгэлээ та бүхэнд товчхон сонордуулъя. Та бүхнийг орчуулгын онол, арга, зарчим гэсэн сэдвээр мэтгэлцээн өрнүүлээсэй гэж хүсч байна.

Тэгэхээр хүн төрөлхтний түүхэнд орчуулгын онолын сэтгэлгээ нь юуны өмнө эртний гүн ухаан, гоо зүйн сэтгэлгээний хөрс суурин дээр үүссэн гэж үздэг юм байна. Тэгэхээр эртний, өрнө дахины гүн ухааны сэтгэлгээнд яруу найруулга гэдэг ойлголтыг хамгийн анх түрүүн эртний Герег, Ромын гүн ухаантан М.Т.Цецерон хөндсөн гэж орчуулгын онолд үздэг юм байна. Дорно дахины тухайд бол гоозүйн сэтгэлгээний тухай ойлголтыг өрнө дахинаас даруй 100-200 жилийн өмнө хятадын их сэтгэгч Күнзийн сургаалд хамгийн анх номлосон гэж үздэг. Күнз бол НОТӨ 551-479 оны хооронд аж төрж байсан эртний хятадын гүн ухаантан сэтгэгч юм. Күнзийг “сайхан хийгээд сайн” гэдэг санааг анх номлосон гэж үздэг. Күнзийн ном сургаал дотор “Эгэл жирийн нь эрхэм тансгаас давбаас болхи толхи больюу, эрхэм тансаг нь эгэл жирийнээс давбаас хоосон хуудам больюу, эрхэм тансаг хийгээд эгэл жирийн хоёр нь эн тэгширвээс сая эрдэмт сайд больюу” гэсэн сургаал байдаг. Энэ сургаалыг өнөөдөр хятадын орчуулгын онолд, хятадын орчуулгын онолын анхны үндэс суурь, эх улбаа гэж үздэг учиртай, яагаад гэвэл энэ бол агуулга хэлбэрийн тухай анх номлосон. Агуулга нь хэлбэрээсээ даваад явчихбал яах вэ, хэлбэр нь агуулгаасаа даваад явчихбал яах вэ, агуулга хэлбэр хоёр тэгширвэл яах вэ гэдгийг анх номлосон номлол гэж үздэг. Монгол орчуулгын онолын сэтгэлгээ бол их өнө эртний уламжлалтай гэдгийг та бүхэн надаар хэлүүлэлтгүй сайн мэднэ. Энэ бол манай эрдэмтэн гүүш нар аль XIII, XIV зууны үеэс эхлэн монгол орчуулгын онолын сэтгэлгээг анх номлож ирсэн байна. Анхны XIII, XIV зууны үеийн хэлмэрч Чойжи-Одсэр, Сономгараа нарын судрын хэлний орчуулга гэж үздэг Шаравсэнгийн уран сайхны чөлөөт орчуулга, дараа нь XV зуун болоход улам хөгжсөөр, XVI зууны үед гүүш Цоржийн урнаар найруулах, сайтар тохиолдуулах хэмээх дэг журам бүрэлдэн тогтсон гэж үздэг байна. XVII зууны үед Зая Бандид Намхайжамцын төвд орчуулгын дэг жаягийн дагуу төвд үгийг үсэгчлэн буулгах, санскрит нэр томъёог үл хэрэглэх зарчим буй болсон байна. XVIII зууны дунд үеэр монгол орчуулгын яруу найртай, утга төгс, мэдэхүйеэ хялбар гэдэг орчуулгын үндсэн 3 зарчим бүрэлдэн тогтож, Дай гүүш Агваандамдин, Цахар гэвш Лувсанчүлтэм нарын утгын найрыг дагаж, яруу зохисоор шүлэглэх зарчим тодорсон, XIX зууны үеэс эхлээд чимэг үгсийг мөр бүрийн эхэнд толгой тэгшлэх журмаар нэмж оруулан, бусад бүх үгийг ягштал мөрдөн орчуулдаг өвөрмөц зарчим тогтсон зэрэг зуун зуун дамжин монгол орчуулгын олон жаяг дэг, зарчмууд тогтож ирсэн гэж орчуулгын онолд үздэг. Өнөөдөр би энд энэ тухай ярихгүй, зөвхөн орчуулгын онолын тулгын гурван чулуу гэж



бидний үздэг орчуулгын гурван бэрх буюу яруу найртай, утга төгс, мэдэхүйеэ хялбар гэдэг зарчмын тухай ярина. Бид Аким гуайтай энэ гурван зарчмыг тойруулан өнөөдрийн их семинарыг хийе гэж ярьж тохирсон байсан. Тэгэхээр та бүхний маш сайн мэддэг Жанжаа хутагт Ролбийдорж, гүүш Шаравжамц, гүн Шаравжав, дай гүүш Агваандампил зэрэг олон эрдэмтэн гүүш нарын оюуны хамтын бүтээл болсон “Мэргэд гарахын орон” гэж алдарт бүтээл байдаг. 1740-1742 оны хооронд туурвисан. Энэ бүтээлийн оршилд “Данжуур”-ийг хэрхэн орчуулах хийгээд, ер нь аливаа орчуулга хийхэд зайлшгүй анхаарч мөрдвөл зохих, орчуулгын онолын зарим чиг баримжаа, жаяг зарчмыг тодорхойлсон байдаг бол өнөөдөр үүнийг эргэн үзэж судалж байдаг ийм судлагдахуун болдог. Гэхдээ энэ талаар нарийвчилсан даацтай судалгаа манайд дутагдалтай гэж үздэг. Жишээлбэл, Аким гуайн тэмдэглэсэн зүйл байдаг, дэлхийд одоо баримталж байгаа онолын бараг бүх зарчмыг 200 гаруй жилийн өмнө бидэнд хэлээд өгсөн “Мэргэд гарахын орон”-оо ч тоймтой судалсан зүйл алга байна хэмээн тэмдэглэсэн байдаг. “Мэргэд гарахын орон” -д зохиогчийн санааг дур мэдэн өөрчилж засахыг цээрлэхийн учрыг дурьдсан байдаг, гол утгыг сайтар номлон, эс чадсан ба буруу номлосон нь илэрхий буй бөгөөс дээрхи голыг зохиогч ямар мэт туурвисан ёсоор орчуулмай. Бас бус голын сайн номлолоос авч засан бүү үйлд хэмээгээд бус бас монголын хэлэн дор шүлэглэсэн хийгээд шүлэглэсний ялгал ба шүлэг дор ч бадаг урт охор тэгш болох тэргүүтэн нь төвдийн хэлнээ ямарчлан эс болвоос бээр шүлэглэсэн мөрүүдийг нь “яруу найртай, утга төгс, мэдэхүйеэ хялбар” гэсэн энэ 3 зарчмыг анх “Мэргэд гарахын орон”-д томъёолсон гэж үздэг. Монголын хэлнээ орчуулахуй дор бодгаль дор үл итгэн, ном дор итгэх, үг дор үл итгэн утга дор итгэхийн үүднээс сайтар мэдэн үйлдмүй гэж “Мэргэд гарахын орон” бүтээлд заасан байдгийг та бүхэн сайн мэднэ. Тэгэхээр энэ “Мэргэд гарахын орон” зохиолд ‘яруу найртай, утга төгс, мэдэхүйеэ хялбар’ гэдэг орчуулгын онолын үндсэн жаяг зарчмын чиг баримжааг чухалчлан дурдаж, үг үсгийг биш утга санааг шүтэн орчуулах ёс зарчмыг тов тодорхой томъёолон заасан байдаг нь дэлхийн улс орнуудын эрдэмтэн мэргэд өөр өөрийн орчуулгын онол зарчмыг боловсруулан хөгжүүлж ирсэн түүхийн их сунгаан дунд монголын эрдэмтэн гүүш нар хоцорч сүүлдсэнгүй, харин ч эн тэргүүнд явж ирснийг гэрчилдэг. Одоо би энэ тухай та бүхэнд сонирхуулж ярихад, юу гэвэл монголын билэгт дуун хөрвүүлэгч нар тэр ‘яруу найртай, утга төгс, мэдэхүйеэ хялбар’ гэдэг орчуулгын үндсэн 3 зарчмыг томъёолсноос хойш, даруй 160 жилийн дараа хятадын соён гэгээрүүлэгч, орчуулагч Янь Фү гэдэг хүн орчуулгын онолын үндсийг анх томъёолсон байдаг. Энэ хүн бол 1853-1921 оны үед амьдарч байсан хятадын их орчуулагч, мөн сэтгэгч хүн байсан. Энэ хүн Хенри Хакселийн “Хувьслын онол”, Адам Смитийн “Үндэсний баялаг”, “Хуулийн амин сүнс” гэдэг номуудыг 1800-аад оны сүүл, 1900-аад оны эхээр англи хэлнээс хятад хэл рүү орчуулсан байдаг юм. Ингэж орчуулахдаа энэхүү Янь Фү гэдэг хятадын сэтгэгч эрдэмтэн бол хятад орчуулгын үндсэн 3 зарчмыг тодорхойлсон. Энэ нь юу вэ гэвэл, “шударгуу үнэн, ойлгомжтой тод, яруу сайхан” гэдэг 3 зарчмыг тодорхойлсон байдаг. “Шударгуу үнэн, ойлгомжтой тод, яруу сайхан”-г бид хятадаар “Синь, Да, Яа” гэдэг. Энэ 3 зарчим өнөөдөр хятад орчуулгын үндсэн зарчим болон өнөөдрийг хүртэл хөгжиж, хятад орчуулгын баримталдаг гол зарчим болсоор байгаа юм. Тэгэхээр өвөрлөгч эрдэмтэд энэ 3 зарчмыг ‘итгэлтэй, шулуун, яруулаг’, ‘нэвтэргүү, шударгуу, урсам’ гэх зэрэг олон янзаар



орчуулан нэрлэж байгаа боловч угтаа орчуулгыг “шударгуу үнэн, ойлгомжтой тод, яруу сайхан” гэсэн 3 зарчмыг л янз бүрээр нэрлэсэн нь юм. Энэ 3 зарчмыг өнөөдөр хятадын орчуулгын онолд Янь Фүгийн онол гэж нэрлэдэг. Янь Фүгийн дурдсан орчуулгын 3 бэрх буюу “шударгуу үнэн, ойлгомжтой тод, яруу сайхан” гэсэн энэхүү зарчим болон монголын эрдэмтэн гүүш нарын “Мэргэд гарахын орон”-д 1470-аад оны үед тодорхойлсон тэрхүү “яруу найртай, утга төгс, мэдэхүйеэ хялбар” гэсэн энэ 3 зарчимтай нэр томъёо утга агуулга яг адилхан байдаг. Харин хятадын эрдэмтэд энэ онолыг 160 жилийн дараа томъёолсон байдаг. Гэтэл Янь Фү хэмээх хятадын онолч сэтгэгч бол англиас орчуулдаг, тиймээс монголын эрдэмтдийн дэвшүүлсэн тэрхүү 3 зарчмыг олж үзсэн гэхэд бол баримт, үнэмшил муутай, учир нь энэ бол онол практикаас үүдэлтэй учир орчуулгын урт удаан түүхийн практикийг нэгтгэн дүгнэж хоёр өөр цаг үед, хоёр өөр улсад дэвшүүлсэн онолын нэгэн дүгнэлт гэж үзвэл илүү зохимжтой болно. Эндээс үзвэл монголын эрдэмтэн гүүш нарын орчуулгын онолын уламжлал бол асар эртний, асар баялаг юм гэдэг нь харагддаг. Янь Фүгийн онолоор бол орчуулгад гурван зүйлийн бэрх буй гэж үзжээ. Энэ нь “шударгуу үнэн, ойлгомжтой тод, яруу сайхан” юм. Зөвхөн шударгуу үнэн орчуулах хэмээх нь туйлын бэрх, шударгуу үнэн орчуулсан атал ойлгомжтой тод бус байх аваас орчуулсан хэдий ч орчуулга биш болох тул ойлгомжтой тод байх нь бас чухал гэж. Энэ хүний онолоор шударгуу үнэн гэдэг бол уг зохиолын эх зохиолд үнэнч хандаж, эх зохиолыг өөрчилж болохгүй, гэтэл түүнийг хүн уншихад ойлгомжтой байх ёстой, бас яруу сайхан байх ёстой. Яруу сайхныг хэт хийгээд байвал шударгуу үнэн гэдэг зарчмаас холдоод явчихна, сайхан яруу зохиол боловч орчуулсан бус зохиосон мэт болно. Хэтэрхий шударгуу үнэнг баримтлаад байвал уг орчуулга маань яруу сайхан байхгүй болно. Тэгэхээр энэ нэгэн зохиол, нэгэн бүтээлд 3-ыг эн тэнцүү илэрхийлэх нь туйлын бэрх юм гэдэг онолыг дэвшүүлсэн байна. Орчуулахууд эх зохиолын гүн гүнзгий утга санааг бүрнээ илтгэх ёстой, үг сонгож өгүүлбэр бүтээх, үг нэмж хасах хийгээд уг эх зохиол өгүүлбэрийн хэв журмыг эс дагах нь олон буй гэж энэ онолоор өгүүлсэн байдаг. Уг зохиолын эх зохиолд чиг шударгуу хандана гэдэг бол агуулгын талыг илэрхийлдэг бол ойлгомжтой тод нь хэлбэрийн талыг илэрхийлдэг. Агуулга нь хэлбэрийг тодорхойлдог, хэлбэр нь агуулгыг илэрхийлдэг, тиймийн учир агуулгад нийцүүлэн хэлбэрийг хувирган, яруу сайхнаар илэрхийлэх нь орчуулагчийн эрхэм үүрэг гэжээ. Орчуулга гэдэг бол бүтээхийн тулд эвдэж, эвдсэний эцэст эргүүлэн бүтээдэг өвөрмөц урлаг гэж үздэгийн учир энд оршдог гэж үздэг. Эх зохиолыг орчуулж буй хэлний зүй тогтлын хүрээнд эвдэж, эх зохиолын утга чанарын хязгаар дотор орчуулгын хэлээр дахин бүтээдэг тийм л урлагийг орчуулагчдаас шаарддаг байна. Энэхүү орчуулгын 3 зарчим бол өөр хоорондоо салшгүй холбоотой, аль нэг нь дутаж дундарч болохгүй, бас аль нэг нь хэтэрч хальж болдоггүй, утга төгс бус аваас зохиолын утгат чанарыг илт гуйвуулж орчуулсан бус зохиосон мэт болно. Мэдэхүйеэ хялбар бус аваас хүн уншихад ер ойлгомжгүй болох, өгүүлсэн найруулсан болхи толхи эрхбиш монгол хэлээр туурвисан атал дахин дахин уншаад эс ойлгохууд хүрдэг нь яруу сайхан нь алга болдог байна. Тиймээс аливаа нэгэн орчуулга хийхэд саяын ярьж өнгөрсөн энэ 3 зарчим эн тэгширч чадваас сая сайн орчуулга болдог. Хэрэв яруу сайхан байхгүй бол шим шүлт үгүй, яруу сайхан монгол хэлний амт шимт үгүй, үлбэгэр сул орчуулга болдог учраас манай орчуулгын онолд өнөөдөр бидний ярьдаг Х.Мэргэн гуайн анх томъёолсон



“увьдас чацуу орчуулга” гэж саяын ярьсан гурван зарчим манай “Мэргэд гарахын орон” зохиолд дэвшүүлсэн тэр гурван зарчим аливаа нэгэн орчуулгад тэгш бүрдэж илэрч чадсан орчуулгыг бид “увьдас чацуу орчуулга” гэдэг. Уг эх зохиолтойгоо ялгагдахгүй мөртлөө уг эх зохиолын бүх шинж төрхийг хадгалж чадсан орчуулгыг өөрөөр хэлбэл “увьдас чацуу орчуулга” гэж нэрлэдэг. Ийм орчуулгын жишээнд олон бүтээлийг дурддаг боловч хамгийн анхны бүтээл бол Д.Нацагдоржийн алдарт “Ханчир сүлд”-ийг ийм увьдас чацуу орчуулгын түвшинд авч үздэг. Тэгэхээр би өнөөдөр та бүхэнд сонордуулсан энэ гурван зарчмыг тойруулан санаа хэлэх үүднээс товчхон хэллээ. Та бүхнийг үнэтэй сайхан санал бодол, зөвлөгөө, үзэл бодол, онолоо бидэнд хэлж өгнө үү гэж хүсч байна.

**Ш.Эгшиг:** Багш маань ерөнхийдөө дорно зүгийн орчуулгын онолын зарчмаас жишээ болгон ярилаа гэж бодож байна. Энд дорно өрнийнхөн бүгд нийлээд суучихсан орчуулгын талаар ярилцах ийм сайхан боломж бидэнд байна. Тэгэхээр эрдэмтэн докторууд та бүхэн өөрсдийн санал бодлоо хэлнэ үү. Их семинар учраас бид ямар нэгэн сэдвээр яриад түүн дээрээ мэтгэлцэж болно, тэр хүний санаатай нийлэхгүй байж болно. Яг эрдмийн сайхан яриа болоосой гэж би бодож байна.

Төмөрхүлэг багш эхэлж ярих уу?

**Т.Төмөрхүлэг:** Онол яриад байх сайхан, яах аргагүй үүнийг дэгээр үйлддэг. Онолын баримжаагүйгээр орчуулга хийнэ гэдэг сохроор тэмтэрсэнтэй адил гэж боддог. Одоо энэ цаг үеийн шаардлага бол амьдрал руу орж бодит байдал, орчуулга юу болж байна гэдгийг бодож, практик тал руугаа орж, бодтой ажил руугаа ормоор байгаа юм. Би зурагтын нэвтрүүлгийг хараад, хачин хачин үг хэллэг сонсоод тэмдэглэж аваад байдаг юм. Залуучуудыг үүнд шүүмжлэлтэй ханддаг л гэж ойлгож байгаа. Телевизийн олон сувгаар хачин хачин юм явж байгаа шүү дээ. Жишээлбэл: үүнийг орчуулагч нөхөд л хийж байгаа алдаа шүү дээ. Тэрнээс болж олон нийт, залуучуудын хэл жигтэйхэн муудаж байгаа гэдгийг та бүхэн бүгд мэдэж байгаа байх. Телевизийн нэг сурвалжлагаар: ‘Тамхины үнэр, жорлонгийн үнэр нар’ гэж олон тоогоор, ‘нар’ гэдэг чинь хүн төрөлхтнөөс бусад зүйлд үл хэрэглэж болно гээд биччихсэн байгаа. Хүүхэд залуучууд тэгэхээр ингэж ярьж байгаа юм. ‘Үхэр, хонь, тэмээ нар’ гэж. ‘Үзэм, гоймон, хэвийн боов нар’ гэж ингэж ярьж байна. Зурагтаар бас ингэж ярьж байгаа юм. ‘Хонины сайн сайхны төлөө’ гэж жишээ нь сурвалжлагч нар ярьж байгаа юм. ‘Хонийг онд мэнд оруулахын тулд’ л гэж байх шиг байгаа юм л даа. ‘Хэцүүгийн эсрэг тэмцэх хэрэгтэй’ гэж байгаа юм. Тэр нь одоо ‘бэрхшээлд сөгдөхгүй’ гэсэн санаа юм шиг байгаа юм. ‘Ногоон амьдралаар амьдарна’ гэж. Энэ чинь ‘архи уугаад ногоорно’ гэж ярьдаг байсан тиймээ, үүнийг хэлж байгаа юм шиг, уг нь бол ‘мод зүлэг тарих’-ыг хэлж байх шиг байгаа юм. Энэ бол нөгөө орчуулагчдын хийж буй ажил. ‘Нүхтэй толгойтой’ гэж ярьж байгаа юм. Тэр нь бол ‘сийрэгхэн ухаантай’ гэсэн үг юм шиг байгаа юм л даа, англи маягийн хэллэгийг махчилж орчуулаад ийм болж байгаа юм. ‘Нэхэмжлэл хангах’ гэж. ‘Нэхэмжлэл барагдуулах’ гэсэн санаа юм шиг байгаа юм. ‘Шороон шуурганд ач холбогдол өгч сэрэмжтэй байхыг анхааруулья’ гэж. ‘Шороон шуурга тавихыг анзаарч сэрэмжтэй байгаарай’ л гэж хэлж байгаа бололтой. ‘Агаарын бохирдлод хувь нэмрээ оруулж байна’. ‘Агаарын бохирдолд нэрмээс болж байна’ гэсэн санаа юм шиг байна.



‘Болгоомжлохгүй бол амиа алдах боломжтой’ гэж. ‘Амиа алдах нь цаад хүсэл нь’ юм шиг. ‘Боломжтой’ гэдэг үг хэллэг жигтэйхэн байгаад байгаа биз, дандаа тийм юун утгаар. Кинон дээр эмэгтэй улс байхад ярихад бараг ичмээр шахуу, хараа биздээ та нар. Сэтгүүлд бичсэн байна лээ, зарим сонинд ч бичсэн байна лээ. Нэг америкийн кинонд нэг эр хүн гоо үзэсгэлэнт бүсгүйтэй тааралдаад: ‘Та их тачаангуй юмаа’ гэж. За эмэгтэй хүнийг ч муухай доромжиллоо доо, яадаг бол гээд л харж байтал нөгөө эмэгтэй чинь зүгээр л үг яриад зогсоод байх юм. Англиар ‘секси’ гэдэг үг нь ухаандаа ‘гоё сайхан харагдах, нүдэнд дулаан, нүд булаам, дур татам харагдах’ гэсэн санааг ингэж хэлдэг. Тэрийг ингэж орчуулаад бантагнуулаад байгаа юм.

**Н.Доржготов:**-Орчуулга биш махчлал байхгүй юу.

**Т.Төмөрхүлэг:** -Харин тийм л дээ. Тэр хүн бол орчуулсан гээд л мөнгө авч байгаа шүү дээ. Кино орчуулсан гээд. Ийм жишээ захаасаа авахуулаад байна. Би ингээд тэмдэглээд байдаг, хоёр гурван зуугаад хуудас болсон, хоёр гурван жил болж байна, ингээд тэмдэглээд л байдаг байхгүй юу. Ерөөсөө авах юм байхгүй. За ингээд хүүхэд залуучуудын хэл жигтэйхэн болсон. Одоо ингээд л асуух юм бол “нар” гээд л ярьчихна. Ийм гунигтай байдалд хүрчихээд байна шүү, олон нийтийн хэл. Хэл ингээд муудахаар яадаг вэ, хэл муудаж, хэл доройтож яваандаа хэл сөнөдөгийн шалтгаан ерөөсөө энэ гэж байгаа шүү. За энэ өвөр монголчуудын хэлийг хараад үзээрэй, дандаа хятад маягаар орчуулсаар одоо хэлний бахдам сайхан шинж нь байхгүй болж байгаа. Тэгэхээр хүмүүс ч, үндэстэн нь хэлээ тоохоо больдог, хэлдээ дургүй, ерөөсөө хятад нь амар юм шиг. Ингэж хэл доройтдог. Ийм гунигтай байдалд хүрчихээд байгаа юм. Яриад байвал их юм бий. Би хэвлэлд бичиж байгаа юм л даа, сонинд гаргах гээд. Би зүгээр та нарт эндээсээ (тэмдэглэлээсээ) хэлж байгаа юм. Хэлийг шинжлэх ухааны хэл гээд яриад байдаг шүү дээ. Шинжлэх ухааны хэл ухаандаа улсын нэр томъёоны комисс гэж байсан. Зуу мянга гаруй нэр томъёо боловсруулсан байгаа юм. Тэр нь бас их хэрэг болсон шүү. Ном орчуулдаг байсан хүмүүст чинь жигтэйхэн сайхан гарын авлага болдог байсан. Одоо тэгвэл тэр ерөөсөө хаягдсан. Одоо жишээлбэл, олон толь бичиг гаргаж байна шүү дээ хүмүүс, ‘концентрац’ гээд нэг үг байгаа юм. Химийн нэр томъёо, хувилахуйн ухааны нэр томъёо. Тэрийг одоо би хэд хэдэн толь бичгээс харлаа л даа, тэгсэн чинь юу юу гэнэ вэ, ‘бөөгнөрөл, цугларал, төвлөрүүлэлт, өтгөрөл’. ‘Өтгөрөл’ гэдэг нь арай ‘концентрац’-даа дөхсөн байгаа юм. Тэгтэл нэр томъёоны комиссын мэдээнд ‘концентрированное удобрение’ гэдэг орос үг байхгүй юу даа. Тэрийг бол ‘аагшуулсан бордоо’ гэж орчуулсан байна л даа, энэ бол жинхэнэ монгол маягтай болоод явчихаж байгаа юм. Тэгтэл толь бичиг хийж байгаа улсууд ингэж орчуулж байгаа юм. За тэгээд одоо бүр хачин хачин юм бичиж, хэл ер нь их доройтох нь. Тийм шинж рүүгээ орчихлоо. Одоо энэ залуучууд, тэдний хүүхдүүд бүр хэлгүй болно. Тэгтэл одоо ерөөсөө манай энэ олон нийт чинь авч байгаа мэдээллийнхээ 70, 80 хувийг орчуулгын зүйлээс авч байна. Тэгэхээр орчуулга нь ийм байхаар чинь хэл доройтох шинж рүүгээ орчихлоо. Хэлэхээр зарим орчуулагч нар уурлаж байх шиг байгаа юм, ийм байдалд хүрсэн, одоо ингээд би тэр бүр нарийн юм ярина гэхээр семинарын хувьд таарахгүй юм шиг байна. 200-300 хуудас болчихоод байгаа, ингээд бичээд байгаа юм.



Би аль тааралдсаныг бичээд байхад л ийм байна. Орчуулгын кино бол ерөөсөө хэрэг алга. Ийм л байдалтай болчихлоо доо та минь ээ.

**Л.Манлажав:** Сая Т.Төмөрхүлэг ярьлаа, хэл гунигтай байдалд орж болох тухай. Тэр үнэхээр тийм. Өнөөдрийн бидний цуглаад ярьж байгаа семинар маань ч гэсэн монгол хэл маань битгий ийм гунигтай байдалд орчихоосой гэсэн, үүнд зориулагдсан гэж бодож байгаа. Аргагүй ээ, Монгол Улсын Их Сургууль бол үүнд их анхаарал тавьж байна. Үүнээс өмнө Олон Улсын Харилцааны Сургуулийн Дипломат орчуулгын тэнхим бол энэ орчуулгын асуудлаар нэлээд олон жил, найман удаа их сайхан хурал хийсэн. Түүнд манай олон багш, орчуулагчид оролцсон. За өнөөдөр бол Гадаад хэл, соёлын сургууль маань үүнд анхаарал тавьж хурал семинар хийж байгаа нь их сайхан санагдаж байна. Энэ бол бас нэгэн тэмдэглүүштэй зүйл, яагаад гэвэл энд маш олон гадаад хэлний мэргэжилтэй улсууд байдаг, ерөнхийдөө одоо энэ орчуулга гэдэг маань бол хоёр хэлний хоорондох гүүр, хоёр хэлний тухай асуудал энд явж байгаа. Ерөнхийдөө ингээд бүр цааш нь авч ярих юм бол даяаршиж байгаа ертөнц, түүнээс өөрийн хэл соёлыг хамгаалах гэсэн үндэстний өөрийн ухамсар хоёрын л асуудал явж байна уу даа гэж тиймээ. Тэгэхээр монгол хэлийг бол, би Төмөрхүлэгээс ч өөрөөс нь асууж байсан. Ази дахинд үлдэх 4 хэлний нэг байсан, хятад, япон, солонгос, монгол гээд явж байгаа, ЮНЕСКО-гоос гаргасан. За энэ бол бас манай өвөг дээдсийн ач гавъяа юм. Монголчууд бол аль дээр үеэс олон хэл мэддэг байсан. Орчуулгын үйлст ч их хувь нэмэр оруулсан, за энэ тухай бол өнөөдрийн М.Чимидцэеэ багшийн тавьсан, түүнтэй холбоотой сайхан илтгэл, сонсголонтой илтгэл байлаа гэж бодож байна. Энэ бол хоёр талтай л юм байгаад байна гэж бодоод байна. Нэг талаас бол монгол хэлнийхээ сургалтыг сайжруулах хэрэгтэй, саяхан засгийн газрын хуралдаанаар монгол хэл бичгийг сайжруулах талаар авч ярьсан, тэр дотор бүр орчуулгын чанар чансаа муу байна гээд тусгай оруулчихсан байж байгаа. За энд л бид нар анхаарлаа чиглүүлэх ёстой юм шиг байна. Эцсийн эцэст монгол хэлнийхээ сургалтыг сайжруулах, монгол хэлээ сайн сургаж байж л гадаад хэлийг сайн эзэмшүүлнэ шүү дээ ер нь. Энэ талаар бол манай хойд хөрш, урд хөрш хоёр аль аль нь их анхаарч байна. Саяхан Путин ерөнхийлөгч нь ч өөрөө сурах бичгийн чанарыг сайжруулъя гээд ярьлаа. Хятадад бас манайхаас ч инээдтэй юм болчихсон, бүх нийтээрээ англи хэл сурна гэхихээд энэ хятад соёлын онцлог юмуу их дээд сургуулийн оюутнууд англи хэл сурахад хамаг цагаа зарцуулаад тэр битгий хэл хятад хэлд нь муугаар нөлөөлөөд байгаа тухай хятад өгүүлэл, хятад хэлний мэргэжилтнүүдийн шүүмжлэлтэй хандсан тухай өгүүлүүд тааралдаж байна. Одоо манайхаас ч гунигтай юм шиг. Сая тэр засгийн газрын хуралдаан дээр ярьсан байна лээ л дээ, сонин дээр гарсан товчхон мэдээн дотор байгаа. Ерөөсөө хэл бичгийн, монгол хэлнийхээ стандартыг хангасан тоо бол гучин гуравхан хувь гарч байна гээд. Хятадад бол бүр тэрнээс доогуур гарсан гээд би нэг өгүүлээс уншсан. Ингэхээр энэ гадаад хэлний сургалт, нэгтээ бид Гадаад хэл соёлын сургуульд, энд сууж байгаа дийлэнхи олон хүмүүс маань ерөнхийдөө нэг бол гадаад хэлний багш, нэг бол орчуулагч улсууд байгаа шүү дээ. Гадаад хэл мэддэг хүн бол ямар нэг хэмжээгээр орчуулагч, бичгээр ч юмуу нэг бол амаар ч юмуу орчуулга хийдэг хүмүүс. Тэгэхээр төрөлх хэлнийхээ сургалтыг энэ завсарт сайжруулах талаар, монгол



хэлнийхэнтэй бид нар хамтарч ажиллах ёстой байх. Энэ талаар МУИС маань анхаарч санаачилж байгаад би их баяртай байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Н.Доржготов:** Өнөөдрийн сэдэвтэй холбогдуулаад их олон сэдэв хөндөж байна. Гэхдээ энд тавьсан ерөнхий тэр орчуулгын зарчим, орчуулгазүй нэг нь юу байлаа, миний бодлоор гурван янзын хурал хийх ёстой том сэдэв. Нэг хурал дээр биш гурван хурал хийж, салбар салбараараа ярих юм бол илүү ашиг өгнө. Өнөөдрийн манай М.Чимидцэеэ багшийн илтгэлтэй холбогдуулаад нэг, хоёр, гурван үг хэлчихье гэж бодож байна. Нэгдүгээрт, Чимидцэеэ багшийн ‘яруу сайхан өгүүлэх’ гэдэг үгэн дээр, энэ бол өнөөдөр бид их бүдүүлэг нэр томъёо хэрэглэж байгаа байхгүй юу. ‘Үгчлэх’ гээд байгаа, ‘махчилах’, ‘үгчлэх’ гэж орчуулж байгаа тэрийг их яруу үгээр хэлсэн байна шүү дээ. Тэр нь яах вэ гэхээр, хэлбэрийг барьчихаж байгаа, хэлбэрийг барьчихаар саяын ярьсан хэлбэр агуулгын нэгдлийг хангаж чаддаггүй юм гээд. Хэлбэрийг бариад үгчилчихээр яах вэ, зарим өгүүлбэрийг яг тэр чигээр нь буулгахаар монгол хэлэнд шал өөр утгатай, зарим нь аймшигтай утга ч илэрхийлдэг. Хэлээр бол тэр юу гэхээр, хоёр хэлний толин дээр тэр үгийг тавьж болно. Яагаад гэхээр хоёр хэлний толь бол үгийн үндсийг л ойлгуулах гэсэн санаа. Орчуулганд зориулсан юм биш шүү дээ, хоёр хэлний толь. Тэгэхээр манайхан яадаг вэ гэхээр орчуулга хийнэ гээд энд сэдвээ авчирч тавиад, нэг гадаад хэлний толь тавьчихдаг. Монгол хэлний толь байхгүй. Хэрвээ орчуулга хийж суръя гэж байгаа бол хамгийн эхлээд монгол үгээ ойлгож сурах. Монгол үгээ ойлгох гэж монгол хэлний толь тавьсан байсан хүнийг би хараагүй. Тэр яаж байна вэ гэхээр, тааж ойлгож байгаа. Тааж ойлгоно гэдэг бол ойлгоц биш. Яагаад тэр монгол хэлийг нарийн ойлгох шаардлагатай вэ гэхээр хэл чинь дотроо нутгийн нарийн ялгаатай байдаг. Харахад нэг үг юм шиг мөртлөө хэрэглээнд ороод ирэхээр шал өөр утгатай. Солонгосын нэг кино харж байхад янаг амрагууд хоорондоо ‘ахаа, ахаа’ гээд байгаа байхгүй юу, манайхан бол тэрийг үзээд ах дүү хоёр хоорондоо сууж болдог юм байна, солонгосчууд. Даяаршиж байгаа үед манайхан яагаад болдоггүй юм гээд ах дүү хоорондоо суувал яах юм бэ. Маш аюултай хэрэг. Солонгосчуудтай би яриад үзсэн чинь, тэр Солонгост хэрэглэдэггүй хар ярианы үгийг кинонд хэрэглэсэн байна. Ерөөсөө тэгж хэлдэг ч үгүй байсан, ‘ахаа’ гэдэг үгийг шилжүүлсэн утгаар хэрэглэсэн. Жишээлбэл, манай орос хэлний толинд бичсэн байгаа юм. “Кузен” гэж үг бий. “Cousin”. “Cousin” нь ямар утгатай гэхээр нэг дэх үе ч бай, хоёр дахь ч бай тэр дотроо манайхан ялгаатай. Нэг дэх үе нь хүү, охин болоод ирнэ, хоёрдахь үе нь ач зээ болоод ирнэ, тэрний дараа ах дүү нар үеэл хаяал болно. Гэтэл тэр “Cousin” гэдэг үгийг “үеэл” гэж орчуулж байгаа хэсэг маань нэг эцгийн хоёр эрэгтэй хүү хоорондоо үеэл болно. Нэг эцгийн хүүхдүүд хоорондоо үеэл болно. Нэг эцгийн хүүхдүүд гэж юу гэсэн үг вэ, одоо нэг хүний үр юм байна лээ шүү дээ. Аа, яг ‘кузен’ гэдэгтэй адилхан монголоор ‘бүл’ гэж хэлж байгаа юм. Тэгэхээр бас ойлгомжтой болж байгаа биздээ, нэг хүний үр биш болчихоод ‘бүл’ гэдэг үг дунд нь ороод ирсэн. Гэтэл тэр толин дээр үүний ялгааг тавиагүй, тэгээд манайхан TV9 байна уу Сансар байна уу нэг өвгөн ярьж байсан. Насыг нь харахад арай ч тийм юм яримааргүй юм, ‘энд нэг кузен улсууд нь юм байнаа’ гэж. Манайхан үүнийг яаж ойлгох вэ, ах дүүс хоорондоо сууж болдог юм байнаа гэж. Гэтэл тэр сууж болдог ‘кузен’ нь Европын хуулиар таван үе өнгөрснөөс хойш эмэгтэй талаасаа сууж болдог явдал бий. Эмэгтэй талаасаа, эрэгтэй



талаасаа бол хаана ч байхгүй. Тэгэхээр ийм мэтчилэнгээр үгийн утгыг ялгаж байж сая орчуулга хийх хэрэгтэй. Тэгж үгийн утгыг ялгаагүй, англи хэлэн дээр ямар байна, орос дээр ямар байна, хятад дээр ямар байна, үгийн ялгааг гаргахгүй толин дээр байгаагаар нь ‘үеэл’ гээд тавьчихаар дараа нь ах дүү хоёрын хүүхдийг хооронд нь суулгаад “хаяна”. Энэ мэтчилэнгээр хэллэг эвддэг. Багш нар маш их эвддэг. Орчуулга заадаг багш нар, тухайлбал энд байгаа бид нар. Нөгөө толины үгийг цээжилчихсэн. Жишээлбэл, нэг лекц уншиж байгаад охидуудаас асуухгүй юу. Та нар нөхөрт гарах уу? гээд. Охидууд ярс гээд гараа өргөж байна. Нөхөр гэж юуг хэлдэг юм бэ гэхээр дуугүй болчихож байгаа юм. нөхөр гэдэг чинь эхнэртэй байж байсан бол нөхөр болно шүү дээ. Эхнэргүй бол гон бие, гозон толгой, эхнэр аваагүй хүнийг хэлж байгаа шүү дээ. Монголчууд эрд гарна уу гэхээс биш нөхөрт гарахгүй нь байна шүү дээ. Та нар хүний татвар эм болох дур байна уу,

**Т.Төмөрхүлэг:**-Тэр битгий хэл эрд гарна ч гэж хэлдэггүй юм. Бухын хөлийн гунж гэж ярьдаг шүү дээ. Хадамд гарах гэж хэлдэг байхгүй юу, монголоор.

**Н.Доржготов:**-Яг нарийн дээрээ бол тийм. Нөхрөөсөө эрд гарах нь арай дээр байгаа байхгүй юу. За тэгэхээр ийм юмнуудыг ялгахгүйгээр үгчилсэн орчуулгаас нөхөр гэж үг үүссэн байна. Намба тогтсон авгай нар хоорондоо ярьж байна, манай охин нөхөрт гарах гэж байна гэж. Манай хуулиар хориотой биздээ, хүний нөхөр салгаж суух нь. Гон бие болгож байж сууна, тэрнээс өмнө авгай нь болж чадахгүй нь байна шүү дээ, татвар эм болно, эсвэл тогооны хүн болно.

**Т.Төмөрхүлэг:**-Энэ хүүхдүүд гол нь мэдэх нь чухал.

**Н.Доржготов:** -Энэ мэтчилэнгээр хэлийг хэн хүнгүй эвдээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр анхаарах асуудал маш чухал. Үүнийг ярьж байж, сая үг сонголтоо хийж чадна. Орчуулганд үг сонголт гээд бид нар ярьлаа шүү дээ сая. Энийг ойлгоогүй бол үг сонголт хийж чадахгүй. Монгол хэл дээр уншиж байгаа номоо ядаж Я.Цэвэл гуайн толийг хүүхдүүд минь хэрэглэж тольдож бай. Европын зүгээр нэг наймаа хийдэг хүний өрөөнд Оксфордын толь байдаг. Та яагаад ингэж байгаа юм бэ гэхэд: Би чинь наймаагаа ашигтай болгохыг хүсч байгаа биздээ, толгойд байгаа үгээрээ бэлдчих юм бол наймаагаа ашиггүй болгож мэднэ, нэг захидлаас болоод бүх наймаагаа “алаад хаячихна”. Тийм учраас тавьж буй үг болгоноо би Оксфордын толиор нягталдаг юмаа гэж. Тэр толины ач холбогдол тэнд байгаа, хэрэглээг тэндээс хардаг. За дараагаар нь орчуулагч бид нар өөрсдөө хэлийг их сайн мэддэг байх. Тэр Т.Төмөрхүлэгийн жишээ бол хангалттай байна. Орчуулагч гэж нэртэй улсууд, хэрвээ жаахан бичгийн үг хэлээр биччих юм бол орчуулагч Рэнцэн (Б.Ринчэнг хэлж байх шиг байна.) гуайн бичсэн юм нойр хүргэх юм гэж ярьдаг. Яагаад гэвэл бичгийн хэлгүй болчихсон улсууд байхгүй юу.

**Ц.Базаррагчаа:**- Ойлгохгүй байхгүй юу.

**Н.Доржготов:** -Ойлгохгүй учраас Рэнцэн гуайн бичсэн юм нойр хүргэж байхгүй юу. Ойлгож байгаа хүн бол унтахгүй, ойлгоогүй хүн бол унтана. Ингэхээр тэр үг сонголт гээч юмыг орчуулга хийж сурах гэж байгаа хүүхдүүд англи дээр ч бай, хятад дээр ч бай,



монгол дээрээ ч бай хоёр хэлний үг сонголтыг зөв хийж байж, сая орчуулагч болох нь байна шүү. Хоёр хэлний. Тэгэхээр үгийн сан дээр ажиллана гэсэн үг. Гэтэл манайд бол өнөөдөр үгийн сан, ялангуяа энэ сургалтын тал дээр их муу. Сая би ойтой хүүхдийн живх авъя гэсэн, тэгсэн нэг охин нэлээн байж байснаа:- Та нэг настай хүнийг хэлж байна уу, 'нэг настай хүнийг' гэж байгаа юм. Тиймээ, хүү минь. Тэгсэн: Та үүнээс хойш памперс авъя гэж бай гэж заасан. Живх гэдэг үгийг мэдэхгүй байгаа юм. Тэгээд насыг нь харахаар гуч гарсан, иймэрхүү үгийн сангийн доройтлууд үүссэн байна. Одоо бас 'муур жирэмсэлжээ' гэж байна, Монголын радиогоор. Муур чинь өөрөө эр амьтан шүү дээ. 'Эр үхрийн сүүгээр тараг бүрнэ' гэвэл хүн амьтан инээнэ биздээ, эр үхрээс шээс гарна уу гэхээс биш сүү гарахгүй шүү дээ. Муураас сүү гарахгүй, сүүн тэжээлтэн болохоор сүүтэй л байх л даа. Тэгэхээр эмийг мигуй, эрийг муур гэж байгаа. Дор хаяад энэ хоёрынхоо ялгааг гаргахгүй. Муур жирэмслэхгүй шүү. Жир гэдэг үг маань юу гэсэн үг вэ, жирэм, жидгэр гэдэг маань хоёр гэсэн үг, тэгэхээр манайд бас л буруудсан байгаа байхгүй юу. Ач, жич, гуч байх ёстой. "Би ачаа харж байна" гэдэг, тэднийд хүү байхгүй, надтай 10 жилд хамт байсан, дөрвөн охинтой. Тэгэхээр дөрвөн зээгийнхээ нэгийг харж байгаа байхгүй юу. Одоо 70 гарч яваа хүн тиймэрхүү хэлний баялагтай байсан шүү. Тэгэхээр үүнийг анзаарч байж үгийнхээ оноолтыг хийхгүй бол хийсэн юм чинь буруу болно. Утгын хувьд бүр эвдэрнэ. Жишээлбэл, би сая уншсан чинь 'хавтгайн буур' гээд байж байх юм. 'Хавтгай' гэж нэгдүгээрт, зэрлэг тэмээг хэлж байгаа юм. Хоёрдугаарт, хавтгайн эмийг хэлдэг юм. Эрийг юу гэх вэ, 'хайс'. Баянхонгорт буудсан улсууд 'хайс' буудсан байх нь байна. Өөрөөр хэлбэл 'хайс' гэдэг үгийг ганцхан гэр тойруулж барьдаг намхан сарзгар хашаагаар ойлгоод байдаг. Амьтан гэж ойлгохоо больсон. Ингэхээр орчуулга хийх гэж байгаа хүн үгийн санг сайн анхаар. Би дахин хэлье. Энэ залуучууд орчуулга хийдэг хүүхдүүд байх шиг байна. Энд явж байгаа хүүхдүүдийг би сайшааж байна. Юм сонсоод авсан байхад, дор хаяж хүнтэй ярьж суухдаа нөхөрт гарахгүй нь байна шүү дээ. Сая нэг хуриман дээр очсон, нөгөө нэг хөгшин хүнд тоглоод байдаг чинь хэн билээ, саяхан гавъяат болсон,

Т.Т.-Шог уу?

Н.Д.- Шогийн. Нэг хөгшин хүнд тоглосоор байгаад.

Т.Т.-Чавганцын дүрд тоглодог уу?

Ц.Б.-Бооёо.

Н.Д.-Аа, тийм. Тэр сая нэг хурим хөтлөлөө л дөө. Тэгсэн чинь "За одоо хадмын тал үг хэлнээ" гэж, яахав хүүгийн эцэг эх хоёр гарлаа. Дараа нь "Төрхмийн тал үг хэлнээ" гэсэн чинь хүн босч ирдэггүй. Тэгсэн 'төрхөм' гэдэг үгээ мэдэхээ байчихаж. 'Төрхмөө үзээд баярласан байна' гээд манайд нэг зүйр үг бий биздээ. Тэр юу вэ гэхээр, эмэгтэй хүний ээж аав хоёр нөхөрт нь төрхөм болно. Эрэгтэй хүний, хүргэний ээж аав хоёр бэрдээ хадам болно. Хүргэний хадам байж болохгүй нь байна шүү дээ. Хүргэний хадам бол төрхөм болох нь.

Т.Т.-Өөрөөр хэлбэл худ, худгуй. Худ гэдэг нь эр талынх нь. Худгуй гэдэг нь эхнэр талынх нь.



Н.Д: -Энэ мэтчилэнгээр үгийн утган дээр ажиллаад дараагаар нь уран найруулгаа хийвэл сайхан орчуулга гарна. Тийм учраас манай дунд сургууль нэг сэргээмээр чухал ажил байна. Биднийг 10 жилд байхад, ямар ч байсан Ц.Базаррагчаа багш мэднэ. Бидний үед 10 жилд үг, үгзүйн хичээл гэж заадаг байсан. Тэр үг, үгзүйн хичээл дээр бол хэдий олон үг тайлбарлаж чадсан хүүхэд дүн авдаг. Одоо энэ бага сургуулийн багш нар л хийлгээд байсан байна шүү дээ. Одоо манайх тэрийг сэргээх хэрэгтэй болсон байна. Улаанбаатарын хүүхдүүд ярьж байгаа шүү дээ, боос гүү гэвэл ойлгох уу?

-Боос ингэ.

-За, боос ингэ гэвэл ойлгох уу? Би нэг лекц хийж байгаад 'боос' гэдэг үгийг тайлбарлах ажил гараад. 'Боос' гэдэг үгийг юу гэж ойлгож байна гэсэн чинь тэндээс нэг хүүхэд гар өргөлөө. Яав? Гэтэл: Одоо бол дарга юмуу даа гэж байна. Дарга ингэ гэж орчуулах нь байна шүү дээ. Тэгэхээр тэмээ, адуу 2 дээр хээлтэйг нь боос гэж нэрлэдэг юм. Тэмээ, адуу 2 дээр. Тэгээд ихээхэн дургүйцдэг нутгийн залууг улсууд загнахдаа "Чи охид боослуулаад яваарай" гэж. Завхай эр байх нь байна шүү дээ. Маш муухай утгаар хэлж байгаа юм шүү. Тэгээд тэр хээлтэй гүүний эд эс гэнэ үү, боос гүүний л гэж байх ёстой шүү дээ, хээлтэй гэж байхгүй. Хээлтэй гэдэг бол уг нь хүн дээр хэлж байсан юм байна лээ, одоо мал дээр хэрэглэдэг болсон. Манайхан буриадуудыг шоолоод байгаа юм л даа, Улаан-Үдэд "Байгаль" гээд нэг зочид буудал бий, тэрний хажууд "Хээлтэй басганд зөвлөгөө өгөх газар" гэж байдаг юм. Би тэнд хэд хэдэн удаа ажлаар очсон, зориуд очиж уншуулахгүй юу, тэгээд манайхан инээгээд байгаа юм. Тэр бол буриадуудын зөв байгаа байхгүй юу. Саван дотор үүссэн, одоогоор бол тэрнийг 'pregress' гэж англиар хэлдэг.

- Монголоор бол тэрийг чинь юу гэдэг байхгүй юу. Шалтаг.

-Тийм, хар ярианд шалтаг гэж байгаа юм.

-Үгүй ээ, үгүй. Бичиг дээр ч шалтаг гэж бий.

-Бичигт байна уу.

-Байна, байлгүй яахав.

-Аа, би юун дээр нь хараагүй. Тийм учраас аль үг, ямар үед ямар утган дээр хэрэглэгдэж байсан гэдгийг анзаарах хэрэгтэй. Хэрвээ тэгэхгүй бол, үгийн судлал хийхгүй бол орчуулга хийх тухай санахын хэрэг байхгүй. Дандаа л одоо хэл мэддэг хүн, уншихаар ерөөсөө дандаа эвгүй. Тэгээд одоо та нар залуу улсууд сайн анзаар. Хэрвээ тэгээд байж байхгүй бол хэдэн жилийн дараагаар нэлээн насжсаны дараа хүүхэд бариад л хүрээд ирдэг юм шүү дээ. Та энийг орчуулсан байна, тэгээд л биччихсэн байна гээд. Тэгэхээр ихээхэн инээдэмтэй юм хийсэн байвал ичнэ биздээ. За энийг залуу улсуудад зориулаад хэлчихье. Миний үг их олдож, үхэр холдлоо.

Н.Д: -Би М.Чимидцэеэ багшийг магтах гэж ирсэн юм. Тэгээд би хожигдохгүй ирсэн. Яагаад гэхээр надад нэг орчуулгын ном өгсөн. Унтаагүй, маш "гоё". Маш сайхан найруулсан. Манай энэ хятад хэлний ангийнхан бол одоо Чимидцэеэ багшаас тэр



монгол хэл дээр яаж орчуулдаг, сонгодог монгол хэлний орчуулгын юмнаас суралцах хэрэгтэй. Ийм авъяастай, сайхан юм бичдэг хүнээс. Барагтай бол унтаад өгнө биздээ, тэр ном юу гэсэн нэртэй байлаа, гүн ухааны ном байсан.

- Күнзийн ном байх,

-Күнзийн сургаал биш байсан.

-Сүнзийн дайтахуйн ухаан.

-Аа тийм байх. Тэрийг барьж авахаар нойр хүрэхгүй сайхан, уйдаггүй ном. Тэгэхээр та нар, заавал хятад хэлнийхэн биш бусад хүүхдүүд ч, хүнд үлгэр жишээ авах нь “гоё” байдаг байхгүй юу. Яаж сайхан найруулдаг юм байна гэдгийг тэндээс сурах хэрэгтэй.

**Л.Чулуунбаатар:** За өнөөдөр сайхан семинар болж байна. Эхлээд М.Чимидцэеэ багш онолын талаар ярьлаа, дараа нь манай ахмад орчуулагч нар өөрийн туршлагаас ярьсан. Тэгэхээр орчуулга гэдэг бол онол, дадлага хоёрын нийлбэр юм. Ухагдахуун бол цаасны хоёр тал шиг нэгдмэл байдаг. Сүүлийн үед, 1950-аад оноос хойш, хэл шинжлэлийн олон урсгал бий болсноос хойш, өөрөөр хэлбэл сэтгэц хэл шинжлэл, хэрэглээний хэл шинжлэл бий болсноос хойш орчуулгыг иж бүрэн судлах, орчуулга нь дотроо бас 2 сална: бичгийн орчуулга, ярианы орчуулга. Уг нь бол олон зууны туршид бичгийн орчуулгын арвин баялаг далай санг судалж, эрдэнийн санг нээж яаж яруу сайхан орчуулсан тэр туршлагыг судалж ирсэн. Шинжлэх ухаан техник хөгжөөд ярианы орчуулгын тансаг сайхныг судлах боломж байна. Ярианы орчуулга нэг удаа ингээд гараад явчихдаг учраас хүний санаанд зарим нэг зүйл нь үлдэж хоцорно уу гэхээс биш тэмдэглэж авдаггүй учир судлагдахууны тал багатай. Сүүлийн үед шинжлэх ухаан, техник хөгжөөд радио телевиз, магнитофон, бичиж авдаг зүйл их болсон учраас хүмүүсийн сайхан орчуулж байгааг бичиж аваад дараа нь задлан шинжилгээ хийгээд судлаад байх бүрэн боломжтой болсон. Тэгээд ч бичгийн орчуулгаасаа ярианы орчуулга асар их бэрхшээлтэй, хүний хүч чадал, цаг зав, энергийг их хэмжээгээр зардаг. Овсгоо самбаа гээд. Түрүүний Т.Төмөрхүлэг багшийн анзаарсан тэр олон жишээ бол манай аман орчуулга хийж байгаа хүмүүсийн алдаатай талын нэг жишээ л дээ. Сүүлийн үеийн орчуулгын онолын тодорхойлолт бол хуучин бол арай өөр байдлаар, бичгийн түүх соёл, орчуулгын түүх соёл, зохиол бүтээл дээр нь хийдэг анализийг голдуу тодорхойлдог байсан. Сүүлийн үед бол орчуулагч хүний оюун ухаанд байгаа ‘менталит’-ыг судлах ёстой. Менталит гэж юу юм бэ гэхээр, тухайн хүний оюун ухааны тархи оюун бүрдсэн, олон жилийн туршлага, мэдлэгийн салбар, дадлага практикийн олон цогц юмыг нийлүүлээд хэлж байгаа юм. Тэгэхээр өнөөдөр бол одоо тэр манай энэ агуу орчуулагч нар, жишээлбэл: Н.Доржготов багш бол “Монголын нууц товчоо”-г монголоос анх орчуулсан, Г.Төмөрчулуун “Монголын нууц товчоо”-г испани хэлэнд анх орчуулсан гээд агуу их туршлага байна. Үүнийг орчуулахын тулд энэ хүний тархи оюунд асар их мэдлэг, асар их туршлага, асар их онол хуралдсан байгаа байхгүй юу. Тэгэхээр өнөөдөр энэ хоёр хүний менталитыг судлах ёстой байхгүй юу. Тэр судалсан судалгааны үр дүнг гаргаад, жишээлбэл дөнгөж орчуулга хийж байгаа оюутан залуучуудад бараг тэр менталит байхгүй шүү дээ. Менталитыг бүрдүүлэхийн тулд өмнөх ухаантан мэргэдийн менталитыг гаргаж, эзэмшин туршлага



болгох ёстой. Хоёрдугаарт менталит, аман орчуулгын тухай жаахан ярьсан. Тэгээд ер нь бол манай орчуулгын онолын талын лекц, юм ярихдаа саяхан болтол өрнөдийн орчуулгын онолын сурах бичиг, судлагдахууны юмыг дээд сургуульд заадаг байлаа. Гэтэл манайд аль Хүннүгийн үеэс бодит баримттайгаар нь дурдах юм бол М.Чимидцэеэ багшийн дурдсанаар бол Чойжи-Одсэрийн үеэс, ер нь бол дорно дахины хэлнээс 6000 гаруй зохиол бүтээл орчуулсан гэж тооцоо байдаг. Хамгийн наад зах нь Ганжуур, Данжуур бол 5000-аад зохиол тэрнээс бусад нь бол мянгаадыг нэмээд. Тэгээд 1983 оны тооцоогоор бол өрнөдийн зохиол бүтээлээс 120 орны 1600 зохиол бүтээл орчуулсан гэсэн. Одоогийн тоогоор нийтдээ гурав, дөрвөн мянга гарсан байна. Тэгэхээр энэ агуу хуралдсан туршлага, энэ арвин баян юмыг оюутнууддаа зааж онолыг нь мэдүүлж, яруу сайхныг мэдүүлж байх нь чухал байгаа юм. Ийм учраас өөрсдийнхөө, монголчуудын олон зуун жилийн туршлагыг багтаасан өргөн хэмжээний сурах бичиг, ном гаргах хэрэгтэй. Орчуулгад бас нэг чухал судалмаар, шаардагдаж байгаа юм юу вэ гэхээр, манай монголын уран зохиолоос, эртний болон орчин үеийн уран зохиолоос гадаадад зөндөө орчуулагдсан. Түүрэн цухас дурдсан, 120 гаруй номон дотор манай энэ хоёр агуу хүний орчуулсан “Монголын Нууц товчоо” байгаа. Америкт Кливез гуай анх орчуулсан англи хэлээр, японд 5 удаа орчуулсан байдаг. Монголоос тэр хэл рүү яаж хийв гэдэг судалж гаргаж ирэх. Ер нь ихэнх судалгаа гадаад хэлнээс монгол руу хийсэн судалгаа байдаг. Өөрийнхөө юмыг гадаад улс оронд яаж гаргаж байна вэ гэдэг. Зарим нэгэн судалгааны эхлэл тавигдаж л байна л даа. Манай Нацагдоржийн охин Н.Ариунзаяа “Үлэмжийн чанар”, Б.Явуухулан гуайн “Би хаана төрөө вэ”-г англи хэлэнд яаж орчуулсан тухай магистрын ажил хийсэн, их сайхан ажил болсон. Тэрнээс харж байхад гадаадын хүмүүс үндэсний онцлогтой үг, монголын зан заншилтай холбоотой үг, өвөрмөц хэлц энэ тэрийг ерөөсөө ойлгодоггүй, хар мухраар ерөөсөө онодоггүй энэ тэр орчуулсан юм зөндөө байдаг. Ямар сайндаа зүгээр л жирийн нэг монголын өгүүллэг орчуулсан нэлээн сайн хэлтэй япон орчуулагч “Хаанаас даа” гэдэг үгийг зүгээр л ‘どこから (doko kara)’ гээд орчуулчихсан. Англиар бол зүгээр л “Where from” гэсэн шиг ганцхан “хаанаас” гэдэг үгэнд гол анхаарал тавиад “даа” гэдэг сул үг бол өөр хийсвэр баймж утгыг огт анзааралгүй шууд тэгээд орчуулсан байх жишээтэй. Тэгэхээр бид өөрийн орчуулгыг гадаад орчуулгатай нь анхаарал тавьж, судалгаа хийж үзэх хэрэгтэй байна. Хоёрдугаарт, аман орчуулга гэж ярихад европ дахинд аль дээр үеэс үүсээд, ерөөсөө зохиолыг уншчихаад уншингуутаа шууд тавьчихаад өөрийн санаанд юу гэж бодогдсоноор нь орчуулдаг тийм бас хэлбэр байсан байна. Түүнтэй адил монгол орчуулган дотор тэр М.Чимидцэеэ багшийн ярьсан олон сайхан, гурван гол тулгуураас гадна бичгийн аман орчуулга гэдэг явж байсан. Тэр нь зүгээр багшаас шавьд, дараа нь тэр хүн дахиад шавьдаа амаар хэлж өгч тогтоолгодог, тийм орчуулга. Хүрэлбаатар гуай маш нарийн судлаад тав зургаан зарчмыг гаргасан байсан. Энэ дээр ерөөсөө тэр судрын хэцүү хүнд хэлбэрийг аман яриа руу ойртуулсан, философийн буюу гүн ухааны олон нарийн ойлголтыг энгийншүүлж, энгийн хүнд ойлгуулахаар нааш нь татсан, тэгсэн мөртлөө тухайн ухагдахууныг илүү сайхнаар хүнд ойлгуулахаар шигтгэж өгсөн. Голцуу шүлэглэхийн эрхэнд өвөрмөц хэлц, хоршоо үгийг илүү түлхүү оруулж өгсөн онцлогуудыг дурдсан. Бас “Үлгэрийн далай” (Do ‘dzangs blun zhes bya ba bzhugs so), “Бодь мөрийн зэрэг” (byang chub lam gyi rim pa chen mo bzhugs so),



“Үлгэрийн ном эрдэнэ цогцолсон” (dPe chos rin chen spungs po shes bya ba bzhugs so) бичгийн орчуулга бол хажууд нь заавал аман орчуулга байна. Тэр хоёрыг харьцуулж үзэхээр аман орчуулга нь уншихад илүү сайхан цагаан, ойлгомжтой байдаг. Тэгээд тэр судрын орчуулгын хажуугаар аман орчуулгын шаардлага байжээ. Түүнийг бас хөгжүүлж байжээ гэдэг юмыг судалмаар байна. За баярлалаа.

**Б.Энхбаяр:** За өнөөдөр Гадаад хэл соёлын сургуулиас энэ “Орчуулга: онол, арга, зарчим” гэсэн сэдэвтэй их семинар зохион явуулж байгаа нь маш сайхан санагдаж байна. Манай сургууль орчуулгатай холбоотой асуудлаар жил болгон хурал зохион явуулдаг. Тэгэхээр бид энэ орчуулгын тулгамдсан асуудлуудыг ярих зайлшгүй шаардлагатай байгаа. Тэгэхээр ийм боломж гарч байна гэдэг үүднээс би маш их талархаж байна. За, орчуулгын чанар, орчуулгаас дамжиж уламжлаад, чадвар муутай, махчилсан орчуулга хийдэг туршлагагүй гэдэг юмуу тийм орчуулагчид үнэхээр монгол хэлийг эвдэж байгаа. Т.Төмөрхүлэг багшийн тэр олон жишээнээс харагдаж байна. Ерөөсөө бид нар ч өөрсдөө мэдэж байгаа шүү дээ. Г.Аким гуай хэлсэн байдаг, “Монгол хэлний амин сүнс бол үйл үг” гэж. Англи, орос зэрэг европ зүгийн хэлэнд нэршүүлэх хандлага давамгайл байдаг. Одоо энэ телевизийн кинонуудыг харсан ч ер нь залуу юмуу, залуу гэлтгүй дээ дунд насны орчуулагчдын орчуулсан ном энэ тэрийг харж байхад тэр англи, орос дээр байгаа нэршүүлсэн хандлагыг тэр чигээр нь монгол руу буулгадаг, монгол хэлнийхээ найруулга зүй, хэлзүй, үгийн хэмжээ тогтолцоог ерөөсөө хайхардаггүй. Энэ маш их хэл эвдээд байгаа юм. Өөрөөр хэлбэл, хамгийн наад талын жишээ гэхэд л телевизээр хүүхдүүд сонсдог л байх. “Чи итгэлтэй байна уу” гээд л асуугаад байдаг юм. Би тэгээд оюутнуудад хэлдэг юм. Та нар өвөө эмээгээ анзаар даа, хэзээ монгол хүн “Чи итгэлтэй байна уу” гэж ярьж байсан юм бэ, ‘Are you sure?’ гэдгийг л хэлээд байх шиг байгаа юм. ‘I hope’ гэдэг үгийг хүүхдүүд “Би итгэлтэй байна” гэж орчуулах жишээтэй. Би энэ дээр их анхаардаг юм. Н.Доржготов багшийн хэлдэг үнэн, орчуулга зааж байгаа манай багш нар өөрсдөө энийг их анхааруулж өгөх ёстой. Зарим орчуулга зааж байгаа багш нар маань өөрсдөө энэ ялгааг мэдэхгүй байна, өөрсдөө энэ ялгааг мэдэхгүй байна гэдэг чинь орчуулгын онолыг судлахгүй байна. Орчуулгын хичээл зааж байгаа багш нар орчуулгын онолыг маш сайн судлах ёстой. Тэгээд нөгөө монгол хэлний нөхцөлт үйл үгийн “-лт” гэсэн дагаврыг залгаад л орчуулдаг. Тэлэлт явагдаж байна, сонголт хийгдэж байна, одоо юу гэдэг юм, дандаа ийм маягаар. ‘Солилт явагдаж байна, солилт хийгдэж байна’ гэх мэт. Бэлэн үйл үг байж байгаа шүү дээ. ‘Солигдож байна, тэлж байна’ ч гэдэг юмуу. Энэ л монгол хэлийг маш их алдагдуулаад байгаа юм. Тэгэхээр тэр чинь муу орчуулагч нар монгол хэлээ мэдэхгүй зүгээр тэр англи, орос, хятад хэлний үгийг тэр чигээр нь сонголтгүйгээр шууд буулгаснаас болж байгаа юм. Тэгээд дээр нь манай залуучуудад бас нэг дутагдал, туршлага муутай орчуулагчид нь тэгж орчуулаад байхаар оюутнууд бол аргагүй шүү дээ. Зааж өгч байгаа юм чинь, ингэж орчуул гээд. Орчуулагчдын бас нэг алдаа бол, энийг бол манай нэртэй орчуулагч Чойжил гуай “Орчуулагчийн жаргал зовлон” гэсэн номондоо маш сайхан тодорхойлж хэлсэн байсан. ‘Бусад оюутнууд, зарим багш нар’ гэж нас тогтсон улсууд нь ч тэгж ярьдаг, бүр сурчихсан, бусад зарим гэсэн үг нь тэртэй тэргүй олон тоо заачихсан үг байж байхад ард нь дахиад “-ууд,-үүд”, “нар” гэсэн олон тооны залгавар залгах ямар ч шаардлага байхгүй шүү дээ. ‘Бусад оюутан, зарим багш’.



Би яахав зүгээр жаахан гадарладаг англи оросоор л жишээ аваад байгаа юм. Англи, орос дээр энэ нэр үгийн олон тоог маш их хэрэглэдэг, монгол хэл рүү нэг тоогоор буулгах ёстой зүйлийг л одоо үүнийг мэдэхгүй юмуу буруу орчуулдаг орчуулагчдын харгайгаар ийм алдаа маш их гарч байна. ‘Ололт амжилтууд’ энэ тэр гэж орчуулдаг, ‘achievements’ гэдэг үг нь англи дээр олон тоогоор хэлэгддэг, монгол хүн хэзээ ч ололт, амжилтууд, бэрхшээлүүд гэж ярьдаггүй шүү дээ. ‘Ололт, амжилт, бэрхшээл’ гэдэг үг чинь өөрөө цаанаа олон утга агуулсан үг шүү дээ. Энэ дээр оюутан хүүхдүүд монгол хэлнийхээ онцлог, монгол хэлнийхээ үйл үгүүдийг их анхаарч байх ёстой. Дээр нь бас орчуулагчдад хэлэхэд, ялангуяа залуучууд, туршлага муутай орчуулагчид сүүлийн үед ерөөсөө орчуулга хийнэ гэдгийг хоёр хэлний толь бичиг тавиад үг шүүрдээд холбож тавиад байхыг л орчуулга хийнэ гэж ойлгодог. Доржготов багшийн хэлж байгаа тайлбар толь, англиас орчуулж байгаа бол Оксфордын тайлбар тольтой байх хэрэгтэй, монгол хэлэн дээрээ Я.Цэвэл гуайн толийг заавал хоёуланг нь тавьж байж жинхэнэ тэр өгүүлбэр, context-д байгаа утганаас аль үг нь тохирохыг олдог байх ёстой, тэгдэг үү та нар? Зарим оюутнууд бол юун хоёр хэлний толь ч байхгүй, яагаад гэхээр мэддэг үг байна, өгүүлбэрээ би ойлгож байна гэдэг. Гэтэл орчуулга хийдэг чадвартай байх тусмаа толь бичиг ашиглах ёстой. Бас залуучуудад хандаад, ер нь зүгээр цаашид анхаараарай гэсэн утгаар хэлэхэд “Мэргэд гарахын орон” гээд түрүүн Чимидцэеэ багшийн илтгэлд гарч байна, тэр уламжлалт орчуулгын онолын их чухал чухал асуудлыг хөндсөн дундад зууны үеийн тэр агуу бүтээлд дурдсан байдаг гэсэн. Би өөрөө ямар уншсан биш, дамжуулахад. Ер нь дундад зууны ийм сайхан заншил байсан байна. “Тухайн орчуулгыг, тухайн бүтээлийг хэний зарлигаар, хэдийд, хаана, хэн орчуулав, тэр орчуулгыг хэн ариутган шүүв” гэдгийг заавал орчуулсан зохиолынхоо ард тавьдаг. Их сайхан уламжлал. Гэтэл одоо сүүлийн үед залуу орчуулагч нар бол ариутган шүүлгэхээ ч больсон шүү дээ. Нэг юм орчуулаад, редактор, хянан ариутгах юм байхгүй шууд өөрийнхөө нэрээр гаргачихдаг. Бичсэн орчуулсан юмаа заавал шүүлгэж, хянуулж байх ёстой гэдэг уламжлалыг л алдагдуулмааргүй байгаа юм. Би ерөөсөө редактор байхгүй ном зөндөө үзсэн. Тэгээд хэн орчуулав гээд нэрийг нь харахаар мэдэхгүй, танихгүй, одоо нэртэй, алдартай орчуулагч Амар гуай ч гэдэг юмуу одоо ч амьд сэрүүн орчуулгаа хийгээд явж байгаа шүү дээ, Доржготов гуай, Төмөрхүлэг гуай ч байдаг юмуу тэд нарын орчуулга бол тэгээд байж байхад болж байна. Гэтэл залуучууд бол заавал туршлагатай хүнээр ариутган шүүлгэж байх ёстой. Ариутган шүүхэд заавал орчуулагч гэхгүй зүгээр монгол хэлээ сайн мэддэг эзэмшсэн хүн ч ариутган шүүнэ шүү дээ, монгол руу орчуулж байгаа үед. Монгол хэл үнэхээр харамсалтай эвдэрч байгаа. Ер нь манайхан бүгд ярьдаг даа, орчуулга биш, ‘оршуулга их олширлоо’ гээд. Энэ зүйлүүд дээр ер нь бол хаа хаанаа анхаарах, бид нар гэхдээ анхаарах цаг болсон гэж их ярьдаг боловч хийгдэж байгаа юм байхгүй байна. За баярлалаа.

**Н.Балжинням:** За, би нэг их тийм орчуулагч ч хүн биш, орчуулгын талаар ярьдаг ч хүн биш. Гэхдээ бас дуулж, уншсан, сонссон юмаа эргэцүүлж бодоход бас зарим зүйл дээр анхаармаар юм шиг санагддаг юм. Орчуулга хийнэ гэдгийг би оюутан байх, оюутны дараах залуу байх үедээ гадаад хэлийг л гаргууд сайн мэддэг байхад гарын доор л гэж бодож байсан юм. Бас яг хүний юм хараад үзээд, өөрөө бас ганц нэг хуудас юм хийгээд үзэхээр тиймгүй юм байна, хамгийн гол нь монгол хэлээ сайн мэдээд, дээр



нь гадаад хэлээ тэрний зэрэгцээ мэдэж байхад л сайн орчуулдаг орчуулагч байдаг гэдгийг би ойлгосон. Багш хүний хувьд шавь нартаа өөрөө хийхгүй ч гэсэн хэлж байдаг юм. Үнэхээр төрөлх хэлний мэдлэг гэдэг бол тэр орчуулга ямар болохыг шийднэ, гадаад хэл бол хамаа байхгүй, төрөлх хэлээрээ гаргууд сайн найруулдаг бол тэгээд шууд л бичиж байгаа шүү дээ. Ч.Чимид гуай хэлсэн байсан, Ц.Базаррагчаа багш ч гэсэн өөрийнхөө юунд тэмдэглэсэн л байна лээ, “Зохиолчдоос би илүү орчуулаад тэднээс илүү үнэлгээ аваад байдаг гээд хүмүүс асуухаар зохиолчид болохоор –Чи гадаад хэл сайтай болохоор ингэж байна гэсэн маягийн юм хэлээд байдаг. Тэгтэл би тэд нараас монгол хэлээрээ найруулж бичиж чаддагаараа л илүү орчуулж чадаж байгаа байхгүй юу, тэгээд би тэд нараас хоёр хэлээрээ даваад байгаа юм” гэж хэлсэн. Тэр бол үнэхээр үнэн байна гэдгийг манай хүмүүс бүгд мэддэг юм байна лээ. Орос хэлнээс монгол хэл рүү орчуулах энэ талын асуудал бол дээр үеэс уламжлалтай, одоо ч гэсэн орчуулагдсаар байгаа. Тэгээд надад нэг тулгарсан бэрхшээлтэй зүйлийг хэлье. Нэг жилийн өмнө нэг Е.М.Даревская түүхч эрдэмтний “Сибирь ба Монгол” гэдэг ном Түүхийн хүрээлэнгээс орчуулагдаад, манай нэг шавь авчраад өглөө. Тэгээд тэрийг харлаа, орчуулсныг нь бүгдийг тулгаж уншдаг, бүгдийг тулгалаа. Тэгээд тэр дотор байгаа манай энэ холилдож байгаа оноосон нэр гарч байгаа болохоор маш хэцүү юмаа. ‘Чита’ гээд хүн орчуулаад ороод ирэхээр тэрийг ‘Чита’ гэж авах юмуу ‘Чит’ гэж авах юмуу, ‘Иркутск’ гээд шууд ороод ирэхээр ‘Эрхүү’ гэхүү ‘Иркутск’ гэхүү гээд л. Одоо ийм асуудал. “Чуко” гээд ороод ирэхээр тэр нь манайхаар “Цөх гол” юм. Тийм ойролцоо юмнуудыг орчуулахад эхлээд зохиолоо орчуулахын өмнө орчуулагч, редактор хоёр хамт сууж байгаад энэ үгийг ингэж ингэж орчуулна, монгол дээр ийм, орос дээр тийм байдаг. Тийм учраас үүнийг ингэж баримтална гэдгийг л хоорондоо тохирмоор юм шиг байгаа юм. Би тэр орчуулагчид нь бас хэлсэн л дээ, “Та дараа дараагийнхаа номыг орчуулах л байлгүй, тэгэхдээ редактор хийх хүнтэйгээ эхлээд сайн ярьмаар юм шиг байна гэж. Тэр хүн хүлээж авсан ч юмуу үгүй ч юмуу ёстой мэдэхгүй. За, энэ бол нэг асуудал. Дараа нь 1910 онд “Оросын Газарзүйн нийгэмлэгээс Монголд явуулсан экспедицийн тэмдэглэл” гээд ном Түүхийн хүрээлэнгээс ороод ирлээ, дандаа манайтай холбоотой ийм нэрүүд гарсан. “Нерчинск” гээд гараад ирэхээр ороод ирэхээр бас л “Нэрчүү”, “нэрчин” гэх юмуу, “нэрч” гэх юмуу, “нэршүү” гэх юмуу гээд бодож явсаар байгаад энд тэнд юм харсаар явтал харин БНМАУ-ын түүхийн 1-р ботид “Нэршүү” гээд биччихсэн, “нэршүү”-гээр нь аваад явуулсан, тэгсэн “нэрчүү” гээд л гараад ирсэн байна. Улсын түүхэнд “Нэршүүгийн уурхай” гээд биччихсэн байгаа байхгүй юу, энийг л баримтлахаас өөр арга байхгүй, “Нэрч гол” гэж байдаг юм байна, тэр гол дээр байдаг уурхай, тосгоныг Нерчинск гээд орос хэлний оронгийн утгатай “-ск” залгаад л. За энд холбогдуулж хэлэхэд ийм ийм зовлон байна. Энэ бол бас зовлон юм байна. Орчуулга хийх хүн ялангуяа өөрсдийнхөө амьдрал ахуйтай холбоотой гадны хүний ном зохиолыг орчуулахаар болвол хамгийн эхлээд нэр ус гэдэг юмыг сайн тогтож яаж хэлбэл зохистойг тогтож байж хийх хэрэгтэй. Тэгэхээр “Енисей” гээд л яваад байдаг, монгол хэлэнд тэрийг чинь “Горлог” мөрөн гээд тэмдэглэхсэн байгаа шүү дээ, Амар мөрөн гээд байдаг, “хар мөрөн” гээд тэмдэглэхсэн байж байдаг, бас “Иртыш” гээд л ороод ирж байгаа юм. Ойрадуудын хэлдгээр “Ирчис”, “Хар ирчис мөрөн” байхгүй юу. Ийм юмнуудыг анхаармаар юм шиг санагдаад, хамгийн гол нь монгол хэлний мэдлэг, эх хэлний мэдлэг нэгдүгээрт юм. Энд



ийм өгүүлбэр ороод ирж байна л даа, “среди белодня, в город находившимися вposedном положений, кормик сам Унгерн в монгольском халате, на любимой кобыле” гэдгийг (С.Л.Кузьминий “Барон Унгерны түүх” гэдэг Түүхийн хүрээлэнгээс гарсан номонд) “Бүслэлтэд байсан хот руу өдрийн цагаан цагт Унгерн монгол дээл өмсөн өөрийн цагаан морийг унаад нэвтрэн орсон байна.” гэж. “Среди белодня” гэж орос хэлний хэвшмэл үг л дээ, ‘гэгээн цагаан өдөр, гэрэлтэй шар нарны доор’ гэж. Тэгэхэд ‘өдрийн цагаан цаг’ гэхээр ухаан нь ‘өдрийн хар цаг’ гэж бас баймаар юм шиг байгаа байхгүй юу. Энэ бол засагдсан. “на любимой кобыле” гэж Барон Унгерн ‘хайртай цагаан гүүгээ унаад’ гэж. Барон цагаан гүүг байнга унадаг байсан байна, тэр нь ямар учиртай гүү вэ гэхээр эрмэг, хэзээ ч унагалж байгаагүй, мориноос ч хол зам туулах чадалтай юм байна. Тэгэхээр “Чингисийн хоёр загалын тууж”-д ч байгаа шүү дээ, ‘эрмэг цагаагч гүүнээс эр хоёр загал төрсөн’ гээд. Тэр цагаан морь гэдгийг би “Эрмэг цагаагч гүүгээ унаад” гэж орчуулсан л даа. Тэрийг бол харин зассан байна лээ.

*Дуу хураагуураас бичигт буулгасан Э.Бумбилэг*

*Энэ удаагийн эрдмийн хэлэлцүүлэгт оролцсон хүндэт багш, профессор Ц.Базаррагчаа, орчуулагч судлаач А.Цэрэнчулуун, Д.Хандмаа, доктор С.Алимаа, доктор Г.Элдэв-Очир нар бүгд орчуулгын талаар үзэл бодол, үнэтэй зөвлөгөөгөө ярьсан юм. Гагцхүү дуу хураагуурт шингээж авч чадаагүйдээ хүлцэл өчье.*

*Орчуулагч багш, эрдэмтдийн зарим нэгэн үнэтэй санаанаас дор толилуулсу.*

**Ц.Базаррагчаа:** Ерөөсөө энд үүсээд байгаа эх хэлний мөхлийн тухай асуудлыг буй болгож байгаа хүмүүс бол энэ орчуулга зааж байгаа багш нар өөрсдөө байгаа юм. Үүнийг би хатуу хэлэх байна.

**Д.Хандмаа:** Энд ирээд харахад энэ хийж байгаа ажлынх нь нэр “Их семинар” гээд харь үг байна. Хүний нэрийн ард “доктор профессор” гэж бичжээ. “Профессор” гэдэг бол эрдмийн цол, хүнийхээ нэрийн өмнө, бас эрдмийн зэргийн өмнө нь тавих ёстой бус уу. Энэ мэтээр бид өөрсдөө харь үгээс татгалзаж, үг хэллэгээ зөв хэрэглэж эхлүүштэй юм.



**Л.Чулуунбаатар:** Энд цугласан бүгдээр гадаад үгнээс татгалзаж байгаа юм байна. “Их семинар” гэж бас гадаад үг орсон гээд үүнийг ямар үгээр солих тухай ярьж байгаа тул, миний санал бол “ЭРДМИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ” гэж тогтвол яасан юм.

---

**Л.Манлажав:** Орчуулагч хэлмэрч нар монгол хэлээ сайн сурууштай юм. Орчуулгын судлаач эрдэмтэд нь монгол хэлнийхэнтэй их л хамтарч ажиллах хэрэгтэй дээ.

---

**А.Цэрэнчулуун:** Энэ танхимд олон оюутан залуус цуглажээ. Та нар бас цаашид орчуулга хийх хүүхдүүд байх л даа. Энд багш нараасаа сонссон дуулсанаа их сайн тусгаж авбал сайнсан. Бас эх хэл, монгол бичгээ сайн сурч, зөв сайхан найруулан бичиж сурч байж, сайн хэлмэрч, орчуулагч болдог гэдгийг хэлмээр байна.

---

**Б.Энхбаяр:** Орчуулга хийчихээд зарим хүн, ариутган шүүлгэхгүйгээр шууд хэвлүүлдэг явдал их болжээ. Энэ бол байж болшгүй зүйл төдийгүй эх хэлийг бөхөөж буй нэг шалтгаан мөн. Орчуулгаа заавал гадаад хэл мэддэг хүн гэлтгүй, монгол хэлээр зөв сайн найруулж бичдэг хүнээр үзүүлж, ариутган шүүлгүүлэх ёстой юм.

---

**Г.Элдэв-Очир:** Хуучин хийдэг байсан ажлаа дор хаяхад сэргээмээр байна. Улсын нэр томъёоны комисс, хэвлэл утга зохиолыг хянах газар гэж байлаа шүү дээ. Тэр хэмжээний ажлаа эхлүүлэх, хуучны олохоо больсон сайн орчуулсан ном зохиол, эрдэмтдийн судалгааны бүтээлийг ч дахин хэвлүүлж эхлүүштэй санагдана.

---